

ОЛОН УЛСЫН МОНГОЛ СУДЛАЛЫН ХОЛБОО  
МЕЖДУНАРОДНАЯ АССОЦИАЦИЯ МОНГОЛОВЕДЕНИЯ  
INTERNATIONAL ASSOCIATION FOR MONGOL STUDIES

ОЛОН УЛСЫН МОНГОЛЧ ЭРДЭМТНИЙ V ИХ ХУРАЛ  
ПЯТЫ МЕЖДУНАРОДНЫЙ КОНГРЕСС МОНГОЛОВЕДОВ  
FIFTH INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

2

Ерөнхий редактор: Ш. Бира

Улаанбаатар · 1992

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНЫ ХЭЛНИЙ ХҮЙСИЙН  
ТУХАЙ

6. Зуу <	-ийн - нэг = 1	1
	-ны - нэг = —	100
в. Мянга <	-ын - нэг = 1	1
	-ны - нэг = —	1000

1000 гэх мэт.

4. Харьяалахын тийн ялгалын нөхцлийн -ын /-ийн/, -ны /-ний/ хувилбар хааяа үүссэн холбоо үгийн чөлөөт хэвшсэн алин болохыг ялгана.

-ийн	хогийн машин /хэвшсэн холбоо үг/
хог <	> машин <
-ны	хогны машин /чөлөөт холбоо үг/

гэх мэт. Бяцхан дэлгэрүүлбэл, "Хогны машинаас морь үргээд явчихлаа" гэвэл хог зөөгч машинаас үргэсэн, "Хогийн машинаас морь үргээд явчихлаа" гэвэл золигийн муу машинаас үргэсэн гэсэн утга гарч байгаа нь харьяалахын тийн ялгалын нөхцлийн хувилбараас хамаарч байна.

Мөн харьяалахын тийн ялгалын нөхцлийн -н хувилбар урт хос эгшгээр төгссөн үг бүхэнд биш, зөвхөн "ой", "Алтай", "Хангай", "хий", "дэлхий" гэх мэт ойны, Алтайны, хангайны, гийний, дэлхийний гэсэн хэлбэр үл тохиолдох цөөн үгэнд тохиолдож байгаа нь найруулгад хамаарах хэлний бодит байдал болно.

Харин нохойн-нохойны, гахайн-гахайны, туурайн-туурайн гэх мэт нэг үндсэнд тохиолдож буй -н, -ны хоёулаа харьяалахын тийн ялгалын нөхцөл биш, тодруулбал, -ны нь харьяалахын тийн ялгалын нөхцөл -н нь голдуу хавсрал нэр үүсгэх хэлний зүйн хэлбэр юм гэдгийг тэмдэглэх хэрэгтэй. Учир нь, дээрх үгнүүдэд залгасан -ны нь тийн ялгалын нөхцөл учир бодит утгатай, -н нь тийн ялгалын нөхцөл биш учраас хийсвэр утгатай байгааг дараахь баримтаар тодруулж болно.

Нэгд, "нохойн дуу" гэдэг нь орос хэлний "собачий лай" /тэмдэг нэртэй/ "нохойны дуу" гэдэг нь "лай собаки" /жинхэнэ нэрийн тийн ялгалтай/ гэдэгтэй утга хэлбэр дүйж байна.

Хоёрт, нэг үндсэнд тохиолдох -ны, -н хоёрын утга үүргийн ялгаа "нарны зүг", "наран зүг" гэсэн холбоо үгийн утгын ялгаанаас бүр тодорхой тул урт хос эгшгээр төгссөн үгэнд орсондоо биш хэлний зүйн хэлбэртэй ялгаа байна.

Гуравт, "Шалгалтын нохойн дуу ойртов" гэдгийг "шалгалтын нохойны дуу ойртов" гэж сольж болохгүй байгаа нь -н, -ны хоёрын утга үүрэг ижил биш гэдгийг харуулж байна. Зарим нутгийн аялгуунд энэ хоёр хэлбэрийг солих тохиол байгааг эс тооцвол нэг үндсэнд тохиолдох хэлбэр бүхэн өөр өөр утга үүрэгтэй байдгийн баталгаа болно.

Аливаа хэлэнд эрэгтэй, эмэгтэй хүний хэлний ялгаа нь янз бүрийн төвшинд илэрч байна. Ялангуяа үгсийн саггийн төвшинд хүйсийн ялгаа их тодорхой илэрдэг.

Ф. Энгельс бичихдээ: "хөдөлмөрийн хуваарь дан ганц байгалийн гаралтай бөгөөд зөвхөн эр, эмийн хооронд л хуваарьтай байдаг. Эрэгтэйчүүд нь дайтах, ан гөрөөнд явах, загас барих, түүхий хоол хүнс олох бөгөөд үүний тулд зайлшгүй чухал багаж зэвсэг бэлтгэнэ. Эмэгтэйчүүд нь хоол унд хийх, оёх, нэхэх зэргээр хувцас хунар, хоол хүнсээ бэлтгэж гэрийн ажил эрхэлнэ. Тэдний аль нь ч өөрцгүй эрэгтэйчүүд нь ой хөвчдөө, эмэгтэйчүүд нь гэр орондоо өөрсдийн ажлын салбарт эзэн болцгоож байв" /1379/ гэжээ. Ажил мэргэжлийн энэхүү нарийн онцлогтой холбогдож, хүн төрөлхтний хөгжлийн эртний шатанд хөдөлмөрийн хуваариас хамаарч хэлэнд хүйсийн ялгарал гарсан байна. Мөн хөдөлмөрийн хуваарь, шашин шүтлэгийн өвөрмөц тал, нийгмийн байдлын ялгарах, сэтгэцийн онцлог зэрэг зүйлээс хамаарч аливаа хэлэнд хүйсийн ялгарал гарч /5.152-158/, хэлэхүйн янз бүрийн хэлбэрүүд үүсдэг гэж үзсэн ч бий.

Дундад эртний монгол хэлний ерөнхий хөгжлийн хуулийг танин мэдэхэд Монголын нууц товчоо тулгуур хэрэглэгдэхүүн болж өгдөг. Эрдэмтэд тэр үеийн монгол хэлний хүйсийн талаар зохиол бүтээлдээ тэмдэглэсэн зүйл байна. Академич Б. Я. Владимирцов 1925 онд хэвлүүлсэн "Монгол хэлэн дэх хэл зүйн хүйсийн ул мөр" /2.31-34/ өгүүлэлдээ эртний монгол хэлэнд нэрийн эм хүйсийн залгаврын аргаар үзүүлдэг -*cin*, -*ycin*, -*jin*, -*qan*, -*yi* мэтийн дагаврууд байсныг дурджээ. Ер нь алтай язгуурын хэлнүүдэд, түүний дотор одоогийн монгол хэлэнд хэл зүйн хүйс байхгүй учраас эдгээр хэлбэрүүд нь тайлагдашгүй /загадочный/ мэт байдаг /4.34/ гэж Унгарын монголч эрдэмтэн Д. Кара тэмдэглэсэн байна. Японы монголч эрдэмтэн Ш. Озава 1961 онд хэвлүүлсэн "Дундад зууны монгол хэлний үйл үгийн дагаврын тогтолцоо" /7.33-79/ өгүүлэлдээ монголын нууц товчооны хэлний үйл үгийн дагаврын тухай нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн байна.

Энэхүү илтгэлдээ монгол хэлний хүйсийн тухай асуудлыг Монголын нууц товчооны хэлний жишээн дээр тогтон өгүүлэхийг зорилго. Бид Монголын нууц товчооны хэлний хүйсийг үгийн ба өгүүлбэрийн төвшинд авч үзэв. Үүнд:

1. Монголын нууц товчооны хэлний өгүүлэхүүн нь өгүүлэгдэхүүнтэйгээ хэл зүйн хүйсээр зохицож байжээ. Өөрөөр хэлбэл өгүүлдэр зүйн төвшинд хэл зүйн хүйсээр зохицсон байна.

1.1 Монголын нууц товчооны хэлэнд үйл үгийн өнгөрөн төгссөн цагийг үзүүлэх залгавар бүтээвэр нь -ba/-be, bi гэсэн хэлбэрээр илэрч байна. -ba/be нь эр хүйсийг зааж, -bi нь эм хүйсийг илтгэж байгааг жишээнэс харж болно.

kö'ün inü mene metü toreba 脫納羅 /(\$41-925)  
Temüün neretei niken ökin törebi 脫納羅 /(\$60-1231);  
bodoncar yabuju basa mun-gu üge ügüleba 鳴訪列羅 /(\$34-901)  
tende alan-qo'a eke inü ügülebi 鳴訪列羅 /(\$20-715);  
teyin atala dobnun-mergen ügei bolba 鳴訪列羅 /(\$17-532)  
atala alan-qo'a eke anu ügei bolbi 鳴訪列羅 /(\$22-731).

1.2. Монголын нууц товчооны хэлний үйл үгийн саяхан өнгөрсөн цагийг үзүүлэх залгавар бүтээвэр нь -la'a/-le'e, -ligi гэсэн хэлбэрүүдээр илэрч байна. Эндээс -la'a/-le'e нь эр хүйсийг зааж, -ligi нь эм хүйсийг зааж байсан байна. Жишээ нь: qabici-ba'atur-un kö'ün menen-tüdüin büle'e 不里吉 /(\$45-938) nadaca egeci yisüi neretei nadaca de'ere qan gü'ün-e jokiqui aju'ai sayi güregen güregelen büligi/ 不里吉 /(\$55-480) гэх мэт болно.

1.3. Монголын нууц товчооны хэлний үйл үгийн өнгөрөн үргэлжилсэн цагийг үзүүлэх залгавар бүтээвэр нь -ju'u, -ji'ai/-ju'ai гэсэн хэлбэрүүдээр илэрч байна. Эндээс -ju'u нь эр хүйсийг зааж, -ji'ai/-ju'ai нь эм хүйсийг зааж байсан байна. Жишээ нь: tenggeri-ese jaya'atu töreksen börte cino aju'u 阿主兀 /(\$1-502)

gergei-inü qo'ai-maral aji'ai 阿主兀 /(\$1-502)  
nadaca egeci yisüi neretei nadaca de'ere qan gü'ün-e jokiqui aju'ai 阿主兀 /(\$155-4805) гэх зэрэг болно.

2. Монголын нууц товчооны хэлний тодотгогч нь тодотгуулагчтайгаа хүйсээр зохицож байжээ.

2.1. Монголын нууц товчооны хэлний тодотгогч, тодотгуулагчийн харьцаан дахь эм хүйсийг заагч залгавар бүтээвэр нь -qcin болно. Жишээ нь: qo'aqcin emegen ( § 98-2222)

sartaqcin qonin ( § 181-6203)  
boroqyin-qo'a gergeitu ( §3-512)  
boroqcin qarciqai ( §25-801)  
qo'aqcin ünien ( §121-3124)

гэх мэтээр -qcin залгавар бүтээгэртэй тэмдэг нэрээр тодотгуулсан бүхэн эм төрлийн хүн, амьтныг заасан нэр үг байжээ.

3. Монголчуудын дунд хүмүүсийн нэр алдар нь хүйсийн өвөрмөц онцлог ялгаатай хэрэглэгддэг байсныг монголын нууц товчоонд гарч байгаа эрэгтэй, эмэгтэй хүний нэрийн зүйлээс мэдэж болно.

3.1. Монголын нууц товчоонд гарч байгаа эрэгтэйчүүдийн нэр нь

boroidai ( 3-512) bügünütei ( 10-611)  
barqudai ( 8-529) belgünütei ( 10-611)  
qoridai ( 141-3927) barulatai ( 46-1003)  
ögödei ( 258-10630) besütei ( 47-1018)

гэх мэтээр ихэвчлэн -dai/-dei, -tai/-tei бүтээврийн тусламжтайгаар үүссэн нэрүүд байна.

3.2. Монголын нууц товчооны хэлэнд нэр үгээс нэр үг үүсгэх -jin гэсэн бүтээвэр эм төрлийн хүн, амьтан болохыг залгаврын аргаар илэрхийлж байжээ. Жишээлбэл: boodoncar alginci ha'ulju dumda ke'elitei eme-yi bariju ya'ujin gü'un ci ke en hasaqba tere eme ugulerun jarci'ud adangqan uriangqajin bi ke'eba ( 38-913) эндээс үзэхэд "ya'ujin gü'ün ci, uriangqajin bi" гэсэн хоёр үг нь угтаа "хүн эмэгтэй хүн бэ чи, урианхай эмэгтэй би" гэсэн утгыг илтгэсэн байна. "-jin" хэмээх залгавар бүтээврийн утга нь "эмэгтэй" гэсэн утгатай дүйж байна.

Мөн mongqojin-qo'a gergeitü ( 3-511)  
barqujin-qo'a neretei ökin ( 8-529)  
qorijin-qatun ( 132-3528)  
qunajin bodo ( 195-7104)

гэсэн жишээнүүд ч олдож байна.

3.3. Монголын нууц товчооны хэлэнд нэр үгийн үндсэнд -lun/-lun бүтээвэр залгаж эмэгтэй хүний нэрийг үүсгэж байжээ. Жишээ нь: nomolun eke ( 46-1001)

temüün neretei niken ökin ( 60-1231)  
qutuqtaí ca'alun jirin ökit ( 157-4902)

4. Монголын нууц товчооны хэлэн дэх тооны нэрийн "хоёр" гэсэн хэлбэр нь хүйсээр зохицож хэрэглэгдэж байжээ.

4.1. Дундад эртний монгол хэлний "хоёр" гэсэн тооны нэрийн qoyar гэсэн хэлбэрийг эр хүйст нэрийн тоо заахад, jirin гэсэн хэлбэрийг эм хүйст нэрийн тоо заахад тус тус хэрэглэж байжээ.

Жишээлбэл: orbei soqatai jirin qatut ( 71-1512)  
sece-domoq arqat-qasar bala qoyar kö'üd ( 120-3111)  
yisui-qatun yisuigen-qatun jirin ( 156-4818)  
cinggis-qahan ong-qan qoyar ( 134-3701)  
jaqa gambu jirin ökit ( 186-6404)  
muqali buqa qoyar kö'ud ( 137-3801)

Монголын нууц товчооны хэлэнд хүйсийн ялгамжаа энэ мэтчилэн байгаа нь эртний монгол хэлний хүйсийн ялгааны тусгал мөн.

Орчин цагийн монгол утга зохиолын хэлэнд бор азарга, борогч гүү, гуна, гунж, дөнө, денж, улаан барс жил, улагчин тахиа жил, хатагтай, шарагчин, шивэгчин, елогчин чоно гэх мэтээр малын өнгө зүс, нас болон цаг улирлын тооллыг заахад хэрэглэгдэж байгаа энэхүү хэлбэрүүдийг үгийн хүйсийн хэлбэр байж магадгүй гэж бид үзэж байна.

1. Ф. Энгельс. Өрх гэр, хувийн өмч, төрийн үүсэл. – "К. Маркс, Ф. Энгельс түүвэр зохиол", УОУ боть, УБ., 1971, х. 379.
2. Владимирцов Б.Я. Следы грамматического рода в монгольском языке. – "Доклады Академии Науч", Л., 1925, стр 31–34.
3. Дамдинсүрэн Ц. Монголын уран зохиолын тойм. 1 дэвтэр, УБ., 1957, х. 64–67.
4. Кара Д. Книги монгольских кочевников. М., 1972, стр.34.
5. Крючкова Т. Б. К вопросу о дифференциации языка по полу говорящего. – "Восточное языкознание", М., 1976, стр. 152–158.
6. Озава Ш. Нууц товчооны үйл үгийн зарим дагаврын тухай. – Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал". 1 дэвтэр, УБ., 1961, х. 204–205.
7. Озава Ш. Дундад зууны монгол хэлний үйл үгийн дагаврын тогтолцоо. – "Хэл судлал". Токио., 1961, х.33–79.
8. Панкратов Б. И. Вань-чао би-ши /Секретная история монголов/ М., 1962, 620 стр.
9. Rachewiltz. Index to the Secret History of the Mongols. Bloomington., 1972, 347 p.
10. Ринчен Б. Монгол нэр үгийн нэгэн эм нөхцөлийн тухай. – "Шинжлэх ухаан", УБ., 1944, N 8, х. 37.
11. Санжеев Г. Д. Следы грамматического рода в монгольских языках. – "Вопросы языкознания", 1956, N 5, стр 73–74.
12. Төмөртогоо Д. Монгол хэлний "хоёр" хэмээх тооны нэрийн бүтцийн тухай асуудалд. – "Монголын судлал", ҮП боть, УБ., 1970, х. 279–285.

## МОНГОЛ ЗУРГИЙН ӨНГӨНИЙ АСУУДАЛД

Манай орны-дүрслэх урлагийн төрөл зүйл дотроос хамгийн их дэлгэрсэн, эртний уламжлалтай монгол зураг өнгийн тусламжтайгаар хүрээлэн буй сав шим ертөнцийг дүрслэн харуулдаг. Тиймээс дүрслэх урлагийн бусад төрөл зүйлээс уран зургийн ялгагдах гол онцлог шинж түүний өнгө болно.

Одоогоос 200 гаруй жилийн тэртээ монголын эрдэмтэн Сүмбэ хамбо Ишбалжир /1704–1788/ "Цэцгэн эрх" гэдэг зохиолдоо өнгийг эцэг, эх, хүү, боол гэх зэргээр ангилан үзээд эцэг өнгөнд шунх, хонд, шар, ногоон, арам, тэн энгэсэг долоог оруулжээ/1/. Тэдгээрээс шунх-улаан, хонд-улбар шар, улбар улаан, улаан ухаа, арам-цэнхэрдүү хөх, тэн-номин хөх, энгэсэг-ягаавтар хүрэн байна. Хэрэв харанхуй байранд жижиг нүхээр нарны гэрэл оруулж, түүний замд олон талст призм тавихад эсрэг талын цагаан дэлгэцэнд нарийн тодорхой дэс дараалалтай улаан, улбар шар, шар, ногоон, цэнхэр, хөх, ягаан өнгийн зурвас бий болно. Эдгээр долоон өнгийг Сүмбэ хамбо Ишбалжирын долоон өнгөтэй харьцуулан үзье. Үүнд, улаан-шунх, улбар шар –хонд, шар-шар, ногоон-ногоон, цэнхэр-арам, хөх-тэн, ягаан-энгэсэг болно. Үүнээс үзэхэд Сүмбэ хамбо Ишбалжирын эцэг долоон өнгө олон талст призмын онолын долоон өнгөтэй өөр хоорондоо бараг дүйж байна.

М.В. Ломоносовын анх дэвшүүлж шинжлэх ухаанд баттай болсон үндсэн гурван өнгөнд улаан, ногоон, хөх орно. Тэгвэл монголчууд улааныг галын өнгө, ногооныг газрын өнгө, хөхийг тэнгэрийн өнгө хэмээн үзэж үндсэн гурван өнгөнд тооцож иржээ.

Эсрэг тэсрэг байрласан олон талст призмын тусламжтайгаар дээр дурьдсан долоон өнгийг хураахад цагаан өнгө гөрдөг. Сүмбэ хамбо Ишбалжир "Цэцгэн эрх" зохиолдоо цагааныг эх өнгө гэж бичсэн нь дээрх байдалтай нийлж байна. Энэ бүхнээс үзэхэд монголчуудын өнгийг ялган ангилах, танин мэдрэх нь өндөр байсан нь харагдана.

Одоо мэдэгдэж байгаа зургийн дурсгалуудаас үзэхэд Х зууны үед монгол зураг хоёр чиглэлээр хөгжжээ. Ийнхүү хоёр чиглэлээр хөгжсөн дагуу зургийн өнгө хоёр янзын шийдэлттэй болон салбарласан байна. Үүнд: бөөгийн онгод зэрэг домгийн сэдэвтэй зургийн өнгө болзолт /условный/ байдалтай, бодит амьдралыг дүрсэлсэн зургийн өнгө бодит /реальный/ болжээ. Энэ хоёр чиглэл